



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/357

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 8 нэгж талбарын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны а/326 дугаар захирамжийн хавсралтын "Арвайхээр хурд" ХХК-тай холбогдох заалт, 2012 оны а/333 дугаар захирамжийн Г.Алтангэрэлтэй холбогдох заалт, 2016 оны а/311 дүгээр захирамжийн хавсралтын Н.Бадамсангитай холбогдох заалт, 2016 оны а/311 дүгээр захирамжийн хавсралтын Ц.Шийлэгбаттай холбогдох заалт, 2016 оны а/311 дүгээр захирамжийн хавсралт, 2021 оны А/301 дүгээр захирамжийн Ц.Бумхандтай холбогдох заалт, 2017 оны А/598 дугаар захирамжийн хавсралтын Н.Санлигсүрэнтэй холбогдох заалт, 2019 оны А/661 дүгээр захирамжийн Ц.Бат-Уяатай холбогдох заалт, 2020 оны А/337 дугаар захирамжийн Б.Мөнгөнбаттай холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100763



Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

	Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ² /	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ² /	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1.	“Арвайхээр хурд” ХХК	3551431	5-8 давхар нийтийн орон сууц	2870	Б.Дамдиндорж	ЙЮ47032010	5-8 давхар нийтийн орон сууц	2870	13 дугаар баг, Намнансүрэн-7 дугаар гудамж, 705 тоот	6 жил
2.	Г.Алтангэрэл	ЙЖ86090212	Автомашини засвар, үйлчилгээний газар	750	П.Өлзийбаяр	МА70081112	Автомашини засвар, үйлчилгээний газар	750	12 дугаар баг, Жаргалант-26 дугаар гудамж, 2604 тоот	6 жил
3.	Н.Бадамсанги	ВВ76103116	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	520	М.Лхагваатогтох	ЙЖ72060334	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	520	8 дугаар баг, Рашаант гудамж, 9 тоот	12 жил
4.	Ц.Шийлэгбат	ЙП76031815	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	672	Т.Мөнхтогтох	ЙЙ71110427	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	672	8 дугаар баг, Рашаант гудамж, 8 тоот	10 жил
5.	Ц.Бумханд	ЙЮ59042623	5-8 давхар нийтийн орон сууц	848	Э.Баярсайхан	ЙМ93100910	5-8 давхар нийтийн орон сууц	848	13 дугаар баг Ч.Дамдиншарав-3 дугаар гудамж, 319 тоот	42 жил

6.	Н.Сангисүрэн	ЙП50101011	Гэр, орон сууцны хашааны газар	441	Д.Дуламсүрэн	ЙП50122601	Гэр, орон сууцны хашааны газар	441	13 дугаар баг, Өгөөмөр-1 дүгээр гудамж, 107 тоот	26 жил
7.	Ц.Бат-Уяа	ЙЮ79051884	Гэр, орон сууцны хашааны газар	451	Б.Мөнгөнцэцэг	ЦЖ78082060	Гэр, орон сууцны хашааны газар	451	2 дугаар баг, 13 дугаар гудамж, 12 тоот	13 жил
8.	Б.Мөнгөнбат	ЙС94050612	Амины орон сууц	450	Л.Жамбаа	ЙЮ85111462	Амины орон сууц	450	13 дугаар баг, Дөл-7 дугаар гудамж, 710 тоот	29 жил

1.6. Аймаг сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүг бэлтгэх тоо хэмжээнд хяналт тавьж, аймгийн аж ахуйн нэгж иргэдийн тариалсан ногоон тэжээл, үр тариаг орон нутагтаа нөөц бүрдүүлэх болон худалдан борлуулах ажлыг зохин байгуулж, өвс хадлан бэлтгэх гадны аймаг сум, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулан, чанартай, үнэ хямд өвс бэлтгэн нийлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-т

1.7. Мал мах борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг яаралтай зохион байгуулж ажиллахыг “ӨВ-ЭКО-МИЙТ”-ХХКомпанийн захирал (Д.Мөнхтөр)-д

Хоёр.Өвөл, хаврын цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг орон нутагт шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор дараахь ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай:

2.1. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах;

2.2. Энэ захирамжийн хавсралтаар батлагдсан сумын түвшинд бэлтгэх, аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг чанартай, заасан хэмжээнд бүрдүүлэх;

2.3. Малчин, мал бүхий иргэн байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд анхаарч зохион байгуулалтыг ханган ажиллах;

2.4. Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч гэрээний дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;

2.5. Отроор өвөлжиж, хаваржих малчин өрхийн судалгаа гаргаж малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх;

2.7. Отор нүүдлээр явж байгаа малчин өрх тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагаас тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай эд материалын хангамжийг нэмэгдүүлэх, уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах.

2.8. Намрын ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, хүн хүчээр хангаж, хамтран ажиллах.